



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/90

Булган сум

**Хилийн цэргийн 0286 дугаар ангид техник хэрэгсэл
худалдан авахад хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хилийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1, 50.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хилийн цэргийн 0286 дугаар ангийн 0300 дугаар салбарын “Гурван гол” хилийн харуулын хариуцсан хэсэгт камерын хяналтын систем суурилуулах, хилийн цэргийн салбаруудыг нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг техникийн нөхцөл шаардлагад нийцүүлэн, хуулийн дагуу худалдан авахыг захирагч (хурандаа Л.Цогтжаргал)-д зөвшөөрсүгэй.

2.Шаардагдах 25,000,000 (хорин таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийг данс бүртгэлд тусган, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг захирагч (хурандаа Л.Цогтжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

